



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Олон нийтийн оролцоог хангах зарим арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Үндэсний хорооны 2024 оны анхдугаар хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэсний дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор ЗӨВЛӨМЖ болгох нь:

Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт:

1.Хууль тогтоомжийн төслийг албан ёсны цахим хуудсандаа хуульд заасан хугацаанд бүрэн байршуулж, санал авах хугацааг тодорхой заах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах эхний үе шатнаас олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дараах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх:

1.1.Хууль тогтоомжийн төслийн агуулга, зорилгоос шалтгаалан ямар сонирхлын бүлэгт мэдээлэл хүргэхийг урьдчилан тооцоолж, мэдээлэл хүргэх хэлбэрийг сонгох;

1.2.Хууль тогтоомжийн төслийн тойм, тайлбар материалыг сонирхол татахуйц, ойлгомжтой байдлаар бэлтгэн иргэд, олон нийтэд цаг тухайд нь хүргэж, санал өгөх, хэлэлцүүлэгт оролцох идэвхийг нэмэгдүүлэх, асуулт, тодруулга авах боломжийг бүрдүүлэх үр дүнтэй арга хэрэгслийг ашиглах;

1.3.Олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зэрэг уламжлалт арга хэлбэр, d-parliament, lawforum цахим платформоос гадна иргэдийн өргөн хүрээг хамардаг харилцааны суваг, платформ, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, гар утасны аппликейшн зэрэг орчин үеийн дэвшилтэт арга хэрэгсэл болон сурталчилгааны самбар ашиглах, иргэдэд цахим шуудангаар захидал илгээх зэргээр хууль тогтоомжийн төслийг олон нийтэд хүргэх, таниулах арга барилыг боловсронгуй болгох.

2.Иргэд, олон нийтийн саналыг хууль тогтоомжийн төсөлд тусгасан тухай саналын товчоо бэлтгэх, иргэдийн саналыг тусгасан, тусгаагүй эсэхээр нь ялгасан байдлаар саналын талаар товч мэдээллийг хураангуй хэлбэрээр бэлтгэн цахим хуудсандаа байршуулах, хэлэлцүүлгийн үр дүнг баримтжуулж, олон нийтэд мэдээлэх замаар ил тод байдлыг хангах;

3.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах Ажлын хэсэг болон уг чиг үүргийг хариуцдаг төрийн албан хаагч болон иргэний нийгмийн байгууллагын гишүүдийн чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн оролцооны ач холбогдлыг ойлгуулах, иргэдийн оролцооны соёлыг сурталчлах;

4.Олон нийтийн оролцооны үр нөлөөг тогтмол үнэлэх, оролцогч талуудаас санал авах, үнэлгээний үр дүн, санал асуулгын судалгааны мэдээллийг ашиглан олон нийтийн оролцоог хангах ажлын үр нөлөөг сайжруулах;

5.Иргэдийн оролцоог хангахтай холбоотой зүйл, заалтыг тайлбарласан, оролцооны арга хэлбэр, олон нийтийн хэлэлцүүлгийг явуулах хугацаа, санал хүсэлтийг үнэлэх шалгуурыг агуулсан танилцуулга, мэдээллийг олон нийтэд түгээх ажлыг хэвшүүлэх.

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

